



ОРХОН АЙМГИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 8/16

Эрдэнэт

Шагнал олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3, 3.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1, Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Шагнах тухай” Б/191 тоот тушаал, Нийтлэг үйлчилгээний албаны дүрмийн 5.8, Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг хангахад хувь нэмэр оруулан, идэвх санаачлагатай ажиллаж байгаа байгууллагын шилдэг ажилтан Лхагвасүрэнгийн Цолмон, Төр засгийн үйлчилгээг эрхлэх газрын “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдсан Мягмаржавын Баярмаа нарт тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгосугай.

2. Шагналыг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас олгохыг нягтлан бодогч /Ц.Ариунчимэгт/-д даалгасугай.

ДАРГА



Г.ПҮРЭВДЭЭ